

БНХАУ-ЫН ӨВӨР МОНГОЛЫН ӨӨРТӨӨ ЗАСАХ ОРНЫ ХИЛИЙН ХУДАЛДААНЫ АСУУДАЛД

Ч.Батцэцэг*

БНХАУ болон түүний хөрш улс орон хоорондоо 22.000 км урт хуурай газраар хиллэдэг бөгөөд түүн дотор үндэстний цөөнхийн бүс нутгийн хилийн шугам 19.000 км гаруйг эзэлж байна. Иймээс Хятадын эх газрын хилийн худалдаа үнэн хэрэгтээ үндэстний цөөнхийн бүс нутгийн хилийн худалдаа болж байгаа юм. Тухайлбал: Өвөр Монголын Өөртөө Засах Орон /ӨМӨЗО/ Хятадын зүүн хойд хэсэгт, зүүн хойноосоо баруун урагшаа үргэлжлэн байрласан өргөн удам нутагтай. Нутгийн хойгуур болон зүүн хойд хэсгээрээ Монгол улс, ОХУ-тай хиллэдэг. Хилийн бүс нутгийг нэгбүрчлэн авч үзвэл, Монгол улсын Дорнод аймагтай Хөлөнбуйр аймгийн Шинэ Баргын баруун зүүн хошуу, Хянган аймгийн Хорчин баруун гарын өмнөд хошуу, Шилийн гол аймгийн Зүүн үзэмчин хошуу, Сүхбаатар аймагтай Шилийн гол аймгийн Зүүн үзэмчин хошуу, Авга хошуу, Сөнид зүүн хошуу, Дорноговь аймагтай Шилийн гол аймгийн Сөнид зүүн баруун хошуу, Улаанцав аймгийн Дархан Муумянган холбоот хошуу, Дөрвөн хүүхэд хошуу, Баяннуур аймгийн Урадын дунд хошуу, Өмнөговь аймагтай Баяннуур аймгийн Урадын дунд хошуу, хойд хошуу, Эзний гол хошуу, Баянхонгор, Говь-Алтай аймагтай Алашаа аймгийн Эзний гол хошуу, Алашаа аймгийн Эзний гол хошуу тус тус хиллэж байна.

1947 онд ӨМӨЗО байгуулагдахаас өмнө Зөвлөлт болон Монгол улстай байлдааны хэрэгцээнд зориулж хилийн худалдаа хийж байсан агаад чөлөөлөгдсөний дараа хилийн худалдааг шинэ шатанд гарган хөгжүүлж, 60-аад оны эхэн хүртэл худалдаа, хамтын ажиллагааны олон гэрээ хэлэлцээрт гарын үсэг зурж амжилттай хэрэгжүүлж байлаа. Үүнээс дурьдвал, 1962 оны 12 дугаар сарын сүүлээр БНМАУ-ын төр засгийн удирдагч Ю.Цэдэнбал БНХАУ-д айлчилж Бээжин хотноо БНМАУ, БНХАУ-ын хилийн гэрээг үзэглэсэн нь 1963 оны 3 дугаар сарын 25-ны өдрөөс хүчин төгөлдөр болжээ. 1964 оны 6 дугаар сард Монгол, Хятадын хилийн

* Ч.Батцэцэг - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, магистр

протоколд гарын үсэг зурснаар Монгол-Хятадын хилийн шугамыг амжилттай тогтоож, хоёр орны харилцааны түүхэнд ихээхэн ач холбогдолтой үйл явдал болсон юм. Гэвч 60-аад оны дунд үеэс 80-аад оны эхэн хүртэл Хятад Монгол, Хятад-Зөвлөлтийн харилцаа үндсэндээ зогсонги байдалд байв.

1982 онд БНХАУ, ЗХУ-ын гадаад худалдаа, хамтын ажиллагааны гэрээ хэлэлцээр байгуулж, орон нутгийн хилийн худалдааг сэргээсэн байна. 1983 онд ӨМӨЗО ЗХУ-ын Алс Дорнод - Сибирийн хооронд орон нутгийн хилийн худалдааг сэргээн байгуулсан байна.

1986 онд Монгол, Хятад хоёр улсын засгийн газрын хооронд худалдааны хэлэлцээр хийснээр худалдааны харилцаа дахин сэргэж эхэлсэн юм. Ийнхүү хоёр тал худалдааны хэлэлцээрт гарын үсэг зурснаар хоёр орны эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааны хүрээг өргөтгөж, цаашдын хамтын ажиллагааны арга хэлбэрийг боловсронгуй болгон, Монгол, Хятадын орон нутгийн хил худалдааг идэвхжүүлж, улмаар хилийн дагуу бүс нутагт эдийн засаг, техникийн хамтын ажиллагааны бүс байгуулах зэрэг тодорхой тохиролцоонд хүрсэн байна.

БНХАУ-д өөрчлөлт шинэчлэл, нээлттэй бодлого хэрэгжүүлэхээс өмнө Өвөр Монгол нь ЗХУ болон Монгол улстай экспорт, импортын бараа солилцооны хэлбэрээр худалдаа хийж, голдуу хонь, үхрийн мах гаргаж, гаднаас тээврийн хэрэгсэл, эмийн бүтээгдэхүүн авч байв. Хилийн худалдаа үндэсний цөөнхийн бүс нутагт онцгой чухал байр эзэлдэг ба гадаадад нээлттэй бодлого явуулж эхэлснээр урьд өмнөхөөс илүү ихээр хөгжиж байна. ӨМӨЗО-д 4221 км хилийн шугам дагуу эдийн засгийн маш идэвхтэй бүс байгуулж, хилийн худалдаагаа сэргээж, 1983 онд 1.1 сая ам.доллар болж өссөн нь 1996 он хүртэл нэмэгдэж, 500 сая ам. долл болж 450 дахин өсчээ.

Өнөөдөр Монгол, Хятадын хилийн боомт, тэдгээрийн дэглэмийн тухай Монгол улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын 1991 оны 6 дугаар сарын 24-ний Хэлэлцээр, түүний хавсралтаар баталсан хилийн боомтуудын байршил, төрөл, ажиллах хугацаанд өөрчлөлт оруулсан, 1995 оны 2 дугаар сарын 29-ний өдрийн Хэлэлцээрийн дагуу БНХАУ-тай хил залгаа 10 боомтоор /үүнээс 9 нь улирлын ажиллагаатай/ талуудын гадаад худалдаа эрхлэх эрх бүхий байгууллагуудын хооронд бараа солилцоо,

чөлөөт валютын зэрэг олон хэлбэрээр хилийн худалдааг явуулж байна. 1998 онд Хятад, Монголын худалдааны нийт хэмжээнд Өвөр Монгол болон Монгол улсын худалдаа 41 хувийг эзэлж байв. Монгол улс Өвөр Монголын хилийн худалдаа тасралтгүй өсөн нэмэгдэж сүүлийн хэдэн жилд 50-80 сая ам. долларын түвшингээ барьсаар байна. 2000 оны эхний хагас жилийн байдлаар Монгол Улсын нийт экспортын 67,3 %, импортын 21,4 % БНХАУ-д ногдож байна. Манай экспортын барааны 80 орчим хувь нь анхан шатны боловсруулалт хийгдээгүй түүхий эд байна. Үүнээс гадна манай улсаас гадаад орнуудад гаргадаг гол нэрийн 47 төрлийн барааны 24 төрөл нэрийн барааг зөвхөн Хятадал гаргадаг. Импортын барааны ихэнхи хувь нь бэлэн бүтээгдхүүн байдаг. Манай улсын зах зээлд хилийн худалдаа онцгой байр эзэлж голлох нөлөөтэй байна.

Хил худалдаа өргөжиж, ач холбогдолтой байгаа хэдий ч хоёр талын аж ахуйн нэгжүүдийн хооронд төлбөр тооцоогоо цаг хугацаандаа хийдэггүй, дутуу төлбөр хийдэг, бараа таваараа дутуу нийлүүлдэг, хууль бус худалдаа явуулдаг, Хятадын хилээр нэвтрэх манай иргэдийн тээврийн хэрэгслээс авах татвар хураамж өндөр, олон төрөл байгаа, зарим бараа чанарын баталгаагүй, зөрчилтэй нийлүүлэх явдал бүрэн арилаагүй, хуурамч гэрээ ашиглаж худалдаа хийдэг гэх мэтийн хүндрэлтэй асуудлууд гарч байна. Эдгээр нь гол төлөв жижиг пүүс, аж ахуйн нэгж, хувь хүмүүсийн хооронд гардаг асуудал мэт боловч хоёр орны гадаад худалдааны нэр хүндэд муугаар нөлөөлөх, харилцан итгэлшлэлийг сулруулах талтай. Иймээс манай талаас гадаад худалдааны үйл ажиллагааг журамлаж, цэгцлэх, ялангуяа хил худалдааг цэгцтэй хөгжүүлэхэд ихээхэн анхаарч, хилийн боомтуудыг тохижуулахад засгийн газар, орон нутгийн засаг захиргаа бололцоогоо бүрэн дайчилж, хил худалдаа явуулах нөхцлийг хангах шаардлагатай байна.

Хятад улсад баримталж буй үндэстний цөөнхийн бүс нутгийг хөгжүүлэх эдийн засгийн чиг бодлого нь тус бүс нутгийн эдийн засгийн хөгжилд зохицуулалт хийж, үндэстний цөөнхийн бүс нутгийн хөгжлийн ялгааг аажмаар багасгахад чиглэж байна. Энэ нь нэгдүгээрт, баруун бүсэд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, хоёрдугаарт, дорно-өрнийн бүс нутгийн харилцаа, хамтын ажиллагааг эрчимжүүлэх, гуравдугаарт, үндэстний цөөнхийн бүс нутгийн ажиллах хүчийг дэмжин нэмэгдүүлэх, дөрөвдүгээрт, хил орчмын үндэстний

цөөнхийн бүс нутгийг гадаадад нээлттэй болгох зэрэг асуудал багтаж байна. Ялангуяа ӨМӨЗО нь хил хязгаарын нутаг болохоор нэлээд алслагдсан, эдийн засаг нийгмийн байдал харьцангуй доогуур, байгаль экологийн тэнцвэр алдагдаж, байгалийн бэрхшээл /ган, зуд/ ихтэй, хөдөөгийн дэд бүтцийн байгуулалт ахиц муутай байсаар иржээ. Байгалийн нөөц баялаг ихтэй боловч нээн ашиглах чадвар сулаас эдийн засаг нийгмийн хөгжилд саад учирч байна гэж үздэг ажээ. Иймээс ХКН-аас баруун бүсийг хөгжүүлэх хэтийн төлөвлөгөөндөө ӨМӨЗО-ыг багтаасан байна. Баруун бүсийг хөгжүүлэх стратегийн бодлогыг хэрэгжүүлэхийн тулд ӨМӨЗО өөрийн хөгжлийн төслийг боловсруулан гаргажээ. Үүнд: ӨМӨЗО-ы хил дагуу 18 боомт ажиллаж байгаагаас ялангуяа Эрээн, Манжуур зэрэг газрыг гол болгож нутгийн хойд бүсийн хөгжлийг түргэтгэн, олон улсын эдийн засгийн нээлттэй чөлөөт бүс болгохоор төлөвлөжээ. 1997 онд Манжуур дахь Хятад Оросын худалдааны бүсийг нээсэн байна. Манжуурын боомтоор Биньжоу шугам болон Сибирийн Приаргунскийн төмөр замыг холбож, Эрээн хотын төмөр замын хоёр шугамыг Монголтой холбож, улмаар Замын-Үүд болон Сибирийн их төмөр замтай холбохоор болжээ. Энэхүү хоёр боомт нь олон улсын тээврийг холбон хөгжүүлэх чухал үүрэг гүйцэтгэх юм байна. Үүний зэрэгцээ Монгол, Орос хоёр улс руу чиглэсэн зах зээлийг нээх өргөн бололцоотой тул Хятадын төр засгаас олгож буй хөнгөлттэй бодлогыг бүрэн төгс ашиглаж, хилийн жижиг худалдаа, хил орчмын ард иргэдийн арилжаа наймаа, аялал жуулчлалын худалдаа, түүхий эдээ гаргаж боловсруулах, хил хавийн эдийн засаг техник мэргэжлийн хамтын ажиллагаа зэрэг арга хэлбэрийг сонгож, Монгол улс, ОХУ руу хандсан экспортын хэмжээг ихэсгэх зорилт тавьж байна. Энэ хүрээнд нэгд, аялал жуулчлалын худалдаа, гаалийн бүртгэлийн асуудлыг сайтар шийдвэрлэхээр төлөвлөжээ. Манжуур, Эрээн хотын гаалийн бүртгэлийн ажил одоохондоо тодорхой шийдвэрлэгдээгүй байгаа юм байна. Хоёрт, хилийн жижиг худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн гэрээг хүндэтгэн, харилцан итгэлцлэлийг баримтлахын сацуу тэдний үйл ажиллагаанд хяналт тавьж, хилийн жижиг худалдааг хууль эрхийн дагуу үнэн зөв хэрэгжүүлэн, гадаадын худалдаачдын итгэл хүлээхийг зорьж байна. Гуравт, хяналт шалгалтын ажлыг хялбарчилж, удирдлагын бүрэн эрхийг зохицуулан ажлын бүтээмжийг дээшлүүлж, аж ахуйн нэгжид импорт, экспортоо өргөтгөх боломжийг

илүү олгох, дөрөвт, Монгол, Орос хоёр улсад ӨМӨЗО-оос гаргасан аж ахуйн нэгжийн бөөний борлуулах төвийг байгуулж, борлуулалтыг өргөтгөхөөр тус тус заасан байна.

БНХАУ дахь өөрчлөлт шинэчлэл, нээлттэй бодлогын хүрээнд зүүн хойд бүс нутгийг ОХУ, Монгол, БНАСАУ, Зүүн Европын орнуудад нээлттэй болгож, Манжуур, Хармөрөн, Суйфэн гол, Хуньчун зэрэг хилийн 4 хотыг нээлттэй хоолой болгох, Өвөр Монгол, Хэйлунцзян, Гирин зэрэг мужийг үндэстний цөөнхийн оршин суух эдийн засгийн нээлттэй бүс болгохоор төлөвлөж байна.

Баруун хойд бүсийг нээхийн тулд Төв Азийн 5 орон, Зүүн Европын орнууд, Пакистан, Баруун Азийн орнуудад Синьцзян Уйгурын Өөртөө Засах Орныг гол болгож, 5400 гаруй км хилийн зурвас дээрхи 8 цэгт хилийн худалдааны боомт нээсэн байна. Ийнхүү Хятадын баруун бүсийн үндэстний цөөнхийн бүс нутгийг гадаадад нээлттэй эдийн засгийн чөлөөт бүс болгох чухал нөхцөл бүрджээ.

Өнөөгийн байдлаар Хятадад Манжуур зэрэг хилийн 13 хот нээлттэй болж, эрэг хавийн хилийн дагуух оронтой гадаадад нээлттэй болсон бүс нутагт улсын 50 гаруй чухал цэг боомт, орон нутгийн боомт газар ойролцоогоор 200 гаруй боомт газар тус тус байгуулаад байна. Ийнхүү БНХАУ Баруун бүсийн хөгжлийг түргэтгэж, Дэлхийн Худалдааны Байгууллагад элссэн нь олон улс хоорондын эдийн засаг, хамтын ажиллагааг эрчимтэй хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой болж байна.

2001 оны 1 дүгээр сарын 7-10 –ны хооронд Монгол улсын Ерөнхий сайд Н.Энхбаяр тэргүүтэй төлөөлөгчид БНХАУ-д албан ёсны айлчлал хийсэн нь Монгол-Хятадын худалдаа эдийн засгийн олон талт хамтын ажиллагааг үр ашигтай хөгжүүлэх таатай нөхцлийг бүрдүүлээ. Айлчлалын явцад ӨМӨЗО-д зочилж, Монгол улс, ӨМӨЗО-ы хилийн худалдааг бүхий талаар идэвхижүүлэн хөгжүүлэхэд онцгой үүрэг гүйцэтгэлээ.

АШИГЛАСАН НОМ, ЗОХИОЛ

1. ӨМӨЗО /хамтын бүтээл/ УБ,1998 он
2. Гадаад харилцааны яамны баримт бичиг
3. Монгол, Хятадын харилцаа: нийгэм, эдийн засгийн зарим асуудал /XX зууны 90-ээд он/ УБ, 2001 он
4. Гао цзе, Тогтох, Амар. Миньцзу мао и гайлун (Үндэстний худалдааны товч тойм) Өвөр Монголын Боловсролын Хэвлэлийн Хороо, 1999 он
5. Оронч, Аши, Лю Цзянсинь. Чжунго юй мэngu цзин цзи гуаньси яньчжу (Хятад болон Монголын эдийн засгийн харилцааны судлал) Өвөр Монголын Нийгмийн Шинжлэх Ухааны Эдийн Засгийн Хүрээлэн 1996 он
6. Хилийн арилжааны удиртгал. Хөххот, 1999 он
7. “Солонго” сэтгүүл. 2000.3.7